



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/03

Өвт

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 2 дугаар Цэцэрлэгийн хүүхдийн хоол нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Бат-Эрдэнэ- Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Э.Ууганаа-2 дугаар Цэцэрлэгийн нярав

М.Доржнамжум-2 дугаар Цэцэрлэгийн багш

Б.Янжиндулам-Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга: Г.Болормаа –Эрүүл мэндийн төвийн

нягтлан бодогч

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Болормаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ